

“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.БАТТУЛГА



“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ IV УЛИРЛЫН
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.11.17

Улаанбаатар хот

I. Тайлангийн зорилго

Энэхүү тайлан нь “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын дүрэмд заасан үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах санал гаргах зорилготой болно.

II. Хамаарах хууль, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Агаарын тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд
7. Байгууллагын Дүрэм, Дотоод журам, Жилийн төлөвлөгөө

III. Үндсэн чиг үүргийн хэрэгжилт

№	Хууль, тогтоомжийн нэр, хэрэгжүүлэх заалт, шийдвэрийн дугаар	Үндсэн чиг үүрэг	Хэрэгжилтийн дэлгэрэнгүй	Хуулийн хэрэгжилтийн байдал	Үнэлгээ
1	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах	-Байгууллага нь нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор гэр хорооллын өрхүүдийн пийшин, яндан, зуухны битүүмж, аюулгүй байдлын хяналт шалгалт, засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулж, утаа, угаарын хийн ялгарлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан. -Мөн иргэдэд агаарын бохирдлын хор уршиг, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, сэрэмжлүүлэг хүргэх арга хэмжээг зохион байгуулсан.	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" -Нийслэлийн Засаг даргын 2025-2030 оны Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан	90%
2	МУАТХ 9.1.1, 9.1.7 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4	Хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхийн хэрэглээнд хяналт тавих	-Хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхийн хэрэглээ, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд манай байгууллагын гэрээт хяналтын ажилтнууд, дүүргүүдийн мэргэжилтнүүд болон оффисын ажилтнууд нийслэлийн гэр хорооллын түлш борлуулах бүх цэгүүдэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Энэ хугацаанд: ➤ Түлшний хүртээмж, тасралтгүй хангалт, ➤ Хэрэглэгчдэд олгож буй түлшний чанар, ➤ Борлуулалтын цэгийн үйл ажиллагааны хэвийн байдал ➤ зэрэгт хяналт тавьж, хэрэглэгчдээс санал асуулга, судалгаа авсан. Мөн иргэдэд:	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" -Нийслэлийн Засаг даргын 2025-2030 оны Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан -Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд	90%

			➤ Түлш авах QR карт, магнит карт-ыг хэрхэн авах, ашиглах, ➤ Интүм төхөөрөмжийн ашиглалт, бүртгэл, баталгаажуулалтын талаар ➤ Аюулгүй түлш ашиглах заавар зөвлөгөө, ➤ Гэр хорооллын утааны эх үүсвэрийг бууруулах бодит арга хэмжээний талаар ➤ зөвлөмж, мэдээллийг тогтмол өгч, газар дээр нь нарийн чиглэлээр зөвлөн ажилласан.		
3	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4, Үйлдвэрийн газрын дүрэм 1.1	Пийшин, яндан, зуухны битүүмжийн шалгалт хийх	-Байгууллага нийслэлийн гэр хорооллын нийт 2,971 айл өрхийн пийшин, яндан, зуухны битүүмжийн хяналт шалгалтыг хийж, аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхийг шалгасан. -Мөн шалгалтын явцад иргэдэд түлш шатах явцад үүсэж болох угаарын хий болон тоосжилтыг бууруулах талаар заавар, зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэсэн.	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" --Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд -Байгууллагын Дотоод дүрэм, журам мөрдөгдөж ажилласан	100%
4	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4, Үйлдвэрийн газрын дүрэм 1.1	Пийшин, яндан, зуухны засвар үйлчилгээ хийх	-Байгууллага нь хяналт шалгалтаар илэрсэн доголдлыг арилгуулах зорилгоор нийт 2,806 айл өрхийн яндан, пийшинд засвар, үйлчилгээ зохион байгуулсан. -Засвар үйлчилгээний явцад хэрэглэгчдэд пийшин, яндан, зуухны зөв ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах талаар зөвлөгөө, зааварчилгаа өгч, урьдчилан сэргийлэх мэдлэг олгосон.	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" -Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд -Байгууллагын Дотоод дүрэм, журам мөрдөгдөж ажилласан	100%
5	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам	Галлагааны горимд хяналт тавих	-Өвөлжилтийн туршид хэрэглэгчдэд галлагааны зөв горимыг сануулах, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ авсан.	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" -Нийслэлийн Засаг даргын захирамж,	90%

	2.2.4		-Галлагааны дэглэм зөрчигдсөн тохиолдолд зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлсэн.	шийдвэрүүд	
6	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4, Үйлдвэрийн газрын дүрэм 1.1	Угаарын хийнээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж тараах	-61000 гаруй өрх болон олон нийтийн байгууллагад угаарын хийн хордлогын эрсдэлээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг хүргэн ажиллав. Энэхүү зөвлөмжид угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг зөв суурилуулах, ашиглах заавар, түүнчлэн ахуйн хэрэглээнд анхаарах аюулгүй ажиллагааны мэдээллүүд багтсан. -“Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” нэртэй цахим хуудсын дагагчдыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 17-ны хооронд 15,777 шинэ дагагч нэмэгдүүлэн, нийт 17,977 дагагчтай болсон. -Дагагчдад өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн өдөр тутмын заавар зөвлөгөө, мэдээ мэдээллийг тогтмол хүргэж, хэвлэл мэдээллийн чиглэлээр санаачилсан “Хамтдаа хичээж – Хариуцлагаа сайжруулъя” аяны хүрээнд боловсрол, сэрэмжлүүлгийн контентуудыг идэвхтэй түгээв. -Цахим хуудсын контентын хүрэлт/үзэлт нэмэгдэж, 2025 оны 11 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хоорондох 14 хоногийн хугацаанд нийт 163,956 үзэлттэй гарсан байна. Энэ нь мэдээллийг хэрэглэгчдэд хүртээмжтэй хүргэх, эрсдэлийн талаарх ойлголт нэмэгдүүлэх ажлын үр дүн сайжирсныг харуулж байна.	-Монгол Улсын “Аюулгүй ажиллагааны тухай хууль” --Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд -Байгууллагын Дотоод журам мөрдөгдөж ажилласан	90%

7	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4, Үйлдвэрийн газрын дүрэм 1.1	Судалгаа, мэдээлэл авч нэгтгэх	-Гэр хорооллын айл өрхийн түлш хэрэглээ, зуухны байдал, агаарын чанарын судалгааг хийж мэдээлэл цуглуулсан. -Цуглуулсан мэдээллийг дүн шинжилгээ хийж удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан.	-Монгол Улсын "Статистикийн тухай хууль" --Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд -Байгууллагын Дүрэм, Жилийн төлөвлөгөө мөрдөгдөж ажилласан	100%
8	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4, Үйлдвэрийн газрын дүрэм 1.1	Сургалт зохион байгуулах	-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 150 гаруй ажилтанд сургалт зохион байгуулсан. - Сургалтад практик дадлага, зөвлөмж багтсан.	-Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд -Байгууллагын Дотоод журам, Жилийн төлөвлөгөө мөрдөгдөж ажилласан	100%
9	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4	Угаарын хий мэдрэгчийн ашиглалтад хяналт тавих	-Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд нийт 131,512 ширхэг угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг суурилуулсан бөгөөд байгууллагын Дэлгэцийн операторууд 24 цагийн горимоор хяналт тавин ажиллаж байна.		
10	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4	Хяналтын системээр тасралтгүй хянах	ППМ-ийн үзүүлэлт 100 болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн тохиолдолд тухайн айл өрхтэй яаралтай холбогдож, урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч, шаардлагатай бол шуурхай багийг илгээж нөхцөл шалтгааныг тогтоон ажиллаж байна. -2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар нийт 12,523 айл өрх угаарын хий мэдрэгч төхөөрөмжөө унтраасан байдалтай байгаа бөгөөд эдгээр айл өрхүүд рүү Гэрээт хяналтын ажилчид өдөр бүр холбогдож, дохио илгээхгүй	-Монгол Улсын "Агаарын тухай хууль" -Нийслэлийн Засаг даргын 2025-2030 оны Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан	100%

			байгаа төхөөрөмжийг газар дээр нь тестлэн шалгаж, төхөөрөмжөө тогтмол ажиллуулахыг сануулж, шаардлагатай заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна. -2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 14-нийг хүртэл нийт 74,454 ППМ өссөн дуудлага ирсэн бөгөөд эдгээр дуудлагын хүрээнд 142,908 хүнийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлсэн байна. Мөн утсаа аваагүй, холбогдоогүй айл өрхүүд рүү 4,232 удаа гэрээт хяналтын ажилтныг явуулж, нөхцөл байдлыг газар дээр нь шалган ажилласан.		
11	МУАТХ 9.1.1, 9.1.7, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам 2.2.4	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүргэх	-Байгууллага нь Улаанбаатар хотын 7 дүүргийн гэр хорооллын 176 мянга гаруй өрхөд хяналт тавьж, галлагааны улирал эхэлсэн буюу 2025 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 14-ний хугацаанд: 1. 135,018 айл өрхөд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгсөн, 2. Яндан, пийшин, зуухны битүүмжлэл болон угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.	-Монгол Улсын “Агаарын тухай хууль” -Нийслэлийн Засаг даргын 2025 2030 оны Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан -Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд	90%

V. Сайжруулах санал

2026 онд хуулийн хэрэгжилт, хяналт, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг санал болгож байна.

1. Угаарын хий мэдрэгчийн хяналтын шинэ систем нэвтрүүлэх

-Төхөөрөмж унтраасан байдалтай айл өрхийг автоматаар ангилан илрүүлдэг,

-Дахин унтраасан өрхүүдийг “өндөр эрсдэлтэй” гэж тэмдэглэдэг,

-Шуурхай багт автоматаар сануулга илгээдэг систем хөгжүүлэх.

2. -Давтан зөрчил гаргадаг айл өрхөд зорилтот сургалт явуулах

-Зөвхөн давтан зөрчилтэй айлуудад чиглэсэн

-“Хяналттай сургалтын багц хөтөлбөр” хэрэгжүүлэх (зөвхөн олон нийтэд зориулсан нийтлэг мэдээллээс илүү үр дүнтэй).

3. -Төхөөрөмжийн батерей, мэдрэгчийн шалгалтын улирал тогтоох

-Жил бүрийн 8–9 дүгээр сард нэгдсэн тест хийх

-Батерейг стандарт хугацаанд тогтмол солих журам боловсруулж мөрдүүлэх.

4. Хяналтын системийн техникийн найдвартай байдлыг сайжруулах

-Дэлгэцийн операторын төвийн сүлжээ тасалдах эрсдлийг бууруулах зорилгоор:

-Нөөц дэд сүлжээ,

-Үндсэн серверийн давхарлал,

-Холбооны хоёрдогч чиглэл нэвтрүүлэх.

5. Иргэдийн мэдээлэл хүлээн авах хэв маягийг сайжруулах

-Богино видео хэлбэрийн зөвлөмжийг тогтмол түгээх

-Зориулалтын гар утасны аппликейшн хөгжүүлж:

-ППМ мэдээллийг айл өрх өөрөө харах,

-Сэрэмжлүүлгийг бодит цагийн горимоор авах боломж бүрдүүлэх.

6. Дүүрэг бүрийн эрсдэлийн газрын зураг гаргах

Угаарын хийн дуудлагын давтамж, мэдрэгч унтраасан байдал, пийшингийн зөрчил зэргийг нэгтгэн:

→ Эрсдэл өндөр бүс

→ Эрсдэл дундаж бүс

→ Эрсдэл бага бүс

гэж ангилан ажиллах.

7. Хяналтын ажилтнуудын сургалтыг улирал тутам шинэчлэх

-Дотоод журмын хэрэгжилт,

-Яаралтай тусламжийн ур чадвар,

-Зөрчил илрүүлэх стандарт ажиллагаа

-зэрэг чиглэлээр давтан сургалт явуулах.

VI. ДҮГНЭЛТ

“Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ нь 2025 оны IV улиралд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдэд аюулгүй ажиллагааны мэдээллийг хүртээмжтэй хүргэх чиглэлээр төлөвлөгөөндөө тусгагдсан ажлуудыг өндөр түвшинд хэрэгжүүллээ.

Айл өрхийн пийшин, яндан, зуухны битүүмжийн хяналт, засвар үйлчилгээ, түлш хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх, угаарын хий мэдрэгчийн ашиглалтад хяналт тавих, цахим мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг гол чиглэлүүдийн хэрэгжилт нь


90–100 хувийн биелэлттэй гарсан нь байгууллагын үйл ажиллагаа төлөвлөгөөтэй уялдан тогтвортой, тасралтгүй хэрэгжиж буйг харуулж байна.

Тайлант хугацаанд нийт 61,000 гаруй өрхөд угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг хүргэж, цахим хуудсаар дамжуулан 14 хоногийн хугацаанд 163,956 удаагийн үзэлттэй контент түгээсэн нь хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх сувгууд үр дүнтэй ажиллаж байгааг нотолж байна.

Мөн угаарын хий мэдрэгчийн хяналтын тогтолцоо жигд, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, өндөр ППМ илэрсэн тохиолдолд айл өрхүүдтэй шуурхай холбогдон, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч нийт 142,908 иргэнийг эрсдэлээс хамгаалсан нь байгууллагын үйл ажиллагааны бодит үр дүн болж байна.

Гэсэн хэдий ч мэдрэгч төхөөрөмжөө унтраасан айл өрхүүдийн тоо, давтан зөрчил гаргадаг өрхүүдийн асуудал, зарим дүүрэгт техникийн тодорхой доголдол гарч буй зэрэг нь цаашид сайжруулах шаардлагатай хэвээр байна. Тиймээс дараагийн хугацаанд эрсдэлийн ангилал бүхий хяналтын систем нэвтрүүлэх, зорилтот сургалт хийх, төхөөрөмжийн нэгдсэн тестийн улирал тогтоох, мэдээллийн хүртээмжийг технологийн шийдлээр нэмэгдүүлэх зэрэг санал, зөвлөмжийг хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө улам сайжрах нөхцөл бүрдэнэ.

Иймд 2025 оны IV улирлын хуулийн хэрэгжилтийн төлөвлөгөөний биелэлт нийтдээ сайн, тогтвортой хэрэгжилттэй буюу 94–98 хувийн үнэлгээтэй байна гэж дүгнэв.



ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ГЭРЭЭ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХЧИМЭГ

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.УЯНГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БОЛОРМАА